

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 7 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2019 оны 07 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны хүрээнд:

2019 оны 07 дугаар сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 удаа болж, 15 асуудал хэлэлцэн 10 тогтоол гаргаж, 6 тэмдэглэлээр үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Х хуралдаанаар:

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналыг үндэсний хөгжлийн газарт хүргүүлэх асуудлыг хэлэлцээд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын төсөлд аймгаас Дэд бүтцийн чиглэлээр, Хөдөө, аж ахуй, үйлдвэрлэлийн чиглэлээр, Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр, Нийгэм, шинжлэх ухааны салбарын чиглэл тус бүрээр саналыг тусгуулахаар Үндэсний хөгжлийн газарт уламжлалаа.

2. Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэлэлцээд зарим шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа, хэрэгжээгүй шалтгаануудыг тодруулан дүгнэлт өгч, цаашид хэрэгжилтийг хангуулах талаар хийх ажлыг тодорхойлж, хариуцсан ажилтнуудыг үүрэгжүүлж, хариуцлага, санаачлагыг өндөржүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

3. Аймгийн 2019 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцыг хэлэлцээд улс, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийгдэж буй ажлуудын явцыг ажил тус бүрээр үнэлж, эрчимжүүлэх арга хэмжээ авах, ялангуяа, улсын хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хийгдэж буй 21 ажлын гүйцэтгэлийн явц 15.7 хувьтай байгааг онцгой анхаарч эрчимжүүлж ажиллах, Нээлттэй тендер шалгаруулах зэрэг ажил гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн хурдан шуурхай зохион байгуулах, энэ талын ажил хариуцсан хэлтэс, газруудын ажлыг уялдааг сайтар хангаж, хариуцлага, санаачлагыг улам сайжруулахыг аймгийн Засаг даргад, Хөрөнгө оруулалтын ажлын явцыг шалган дүгнэлт өгч, эрчимжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын, Үйлдвэрлэл дэд бүтцийн бодлогын зэрэг хороодын Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг томилуулан энэ оны 09 дүгээр сард сумдад ажиллуулахыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад тус тус даалгасан.

4. Иргэний зөвлөлийн гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцээд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус иргэний зөвлөлийн гишүүнээр Г.Цэцгээ, Б.Эрдэнэбат нарыг томилов

5. Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Эрүүл мэндийн газар, Аргалант сумын Эрүүл мэндийн төв, Баян сумын Эрүүл мэндийн төв, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын автомашиныг дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг тогтоож, акталж устгах тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Аргалант сумын цэцэрлэгээс Борнуур сумын цэцэрлэгийн балансад шилжүүлэх тоног төхөөрөмж зэргийг батлав. Нээлттэй дуудлага худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу аймгийн төсөвт төвлөрүүлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэх болон уг тогтоолын хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

6. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний эцсийн найруулгыг хэлэлцээд боловсруулалтын түвшинд нэмэлтээр оруулах саналыг тусган дахин танилцуулахаар буцаав.

7. Төрийн дээд одон медальд уламжлах тухай зэрэг нийт 7 асуудал хэлэлцэж 6 тогтоол батлан хуралдааны тэмдэглэлээр 2 үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн XI хуралдаанаар:-

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж бүтэн жилээр ажиллах сүүлчийн жил-2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд онцгой анхаарал хандуулж, ажлын явцад хяналт үнэлгээ хийж, цаашид хийх ажил, авах арга хэмжээг оновчтой тодорхойлон хэрэгжүүлж ажиллах,

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад өгч буй үнэлгээ нь бодит байдлыг зөв тусгаж, цаашид хэрхэн ажиллах арга барилаа тодорхойлох суурь үндэслэл болохыг анхаарч Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг чанд мөрдөхийг аймгийн Засаг даргад даалгасан.

2. Урианы жилийн ажлын хэрэгжилтийн явцын тайланг хэлэлцээд “Бүтээн байгуулалт- хөрөнгө оруулалт” урианы жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 97 ажлын 39,2 хувь нь хэрэгжих шатандаа, 32.0 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 14.4 хувь нь хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн байгаад дүгнэлт хийж төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

3. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын хэрэгжилтэд Аудитын газраас хийсэн Аудитын тайлангийн тухай асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс тус хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож 2019 оны хагас жилийн байдлаар 64.74 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэн “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэж, санал хүргүүлэх тухай” тогтоолыг баталсан.

5. Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн үйлдвэржүүлэх “ЖДҮ:27” төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн үйлдвэржүүлэх “ЖДҮ:27” төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, энэ ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох, хяналт тавих, аймгийн зөвлөл, сумдын салбар зөвлөлийг яаралтай байгуулж, ажлыг нь эхлүүлэн тогтмолжуулахыг аймгийн Засаг даргад даалгасан.

6. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хэлэлцээд ”Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих аймгийн төлөвлөгөө”-г баталсан.

7. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулд санал өгөх, Төрийн дээд, одон медальд уламжлах тухай зэрэг нийт 8 асуудал хэлэлцэж 4 тогтоол батлан хуралдааны 4 тэмдэглэлээр үүрэг өгөв.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Ерөнхий сайдын Аймгийн Засаг даргатай байгуулсан батламжийн эхний хагас жилийн биелэлт, Ерөнхий сайдын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2 дугаар улирлын биелэлтийг тус тус гаргаж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Архуст сумын 60 жил, Баянцогт сумын 90 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд баярын илгээлт хүргүүлж, тус бүр 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

Аймгийн Засаг даргын 27 сумын Засаг даргатай байгуулсан батламжийн 2019 оны эхний хагас жилийн хүртэлх тайланг тус бүр 30 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн.

2019 оны 07 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж, 12 асуудлыг хэлэлцэн холбодох шийдвэрийг гарган ажилласан.

2019 оны 07 дугаар сарын 29-ний байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 61 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар, дээд шатны яам, агентлагийн санал дүгнэлт ирсэн 16 иргэний тодорхойлолтыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох байгууллагуудад уламжилсан. Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 67 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 102 иргэнийг шагнаж, урамшууллаа.

2019 оны 07 дугаар сард сум, байгууллагуудад 5 удаа цахим сургалт хийж, зөвлөмж зааварчилгаа өгсөн. Танхимын 4 удаагийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын хэвийн ажиллагааг хангасан.

Төрийн албаны стандартын хүрээнд: Аймгийн хэмжээнд Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд /үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө/ суурилж төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, нэгтгэлийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Гэрээний /Төлөвлөгөө/ биелэлтийн дүн мэдээ ирүүлэх байгууллагын тоо, хувь	Ирүүлбэл зохих	44
	Ирүүлсэн	40 буюу 91.0%
	Ирүүлээгүй	4 буюу 9.0%
Гэрээний /Төлөвлөгөө/ биелэлтийн дүн мэдээ ТЖАХ-ийн тоо, хувь	Дүгнүүлбэл зохих	543
	Дүгнүүлсэн	501 буюу 93.0%
	Дүгнүүлээгүй	42 буюу 7.0%

Дүн мэдээ хугацаандаа ирүүлээгүй байгууллагууд:

№	Байгууллагын нэр	ТЖАХ-ийн тоо
1	Архуст сумын ЗДТГ	7
2	Баян-Өнжүүл сумын ЗДТГ	7
4	Заамар сумын ЗДТГ	7
НИЙТ ДҮН		21

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар аймгийн хэмжээнд баримтлах чиглэл”-ийн хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар нэгтэн дүгнэж хэлэлцүүлэхэд 76.37%-тай, “Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж, чадавхижуулах хөтөлбөр”-ийн биелэлт 78.0%-тай дүгнэгдлээ.

ТАЗСЗ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.07.29-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	15
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	2
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	1
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-

2019 оны 07 дугаар сарын 29-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Албан бичиг	181	23	23	-	-
2	Өргөдөл, гомдол	26	26	26	-	-

Тайлант хугацаанд салбар зөвлөлөөс 39 албан бичиг гадагш явуулсан.

Гадаад харилцаа: 1994 оноос хамтын ажиллагааны түүхийн хуудсаа эхэлсэн Зүүн Хойд Азийн орнуудын 5 бүс нутаг болох Монгол улсын Төв аймаг, БНСУ-ын Кангвон муж, БНХАУ-ын Жилинь муж, Япон улсын Тоттори муж, ОХУ-ын Приморын хязгаарын Засаг захиргааны байгууллагуудын харилцаа хамтын ажиллагааны Дээд хэмжээний уулзалт 24 дэх удаагийн Саммит 2019-07-29-30-ны өдрүүдэд “Зүүн Хойд Азийн орнуудын бүс нутаг хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах нь” сэдвийн дор амжилттай болов. Арга хэмжээний хүрээнд ЗХА-ийн орнуудын 5 бүс нутгийн Захирагч нарын Зөвлөгөөн, Эдийн Засгийн зөвлөгөөн, Байгаль орчны байгууллагуудын зөвлөгөөн, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын зөвлөгөөнийг зохион байгуулахын зэрэгцээ Зүүн Хойд Азийн орнуудын 5 бүс нутгийн уран бүтээлчдийн 21 дэх удаагийн Уран зургийн үзэсгэлэнг Монголын Уран зургийн галларейд 3 хоногийн турш дэлгэн үзүүллээ. 24 дэх удаагийн саммитад 5 бүс нутгийн 70 гаруй төлөөлөгчид оролцов.

Захирагч нарын зөвлөгөөнөөр 20 гаруй жилийн турш тогтвортой, хамтдаа хөгжүүлж ирсэн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж эдийн засаг, худалдааны харилцаа руу хандуулж ажиллах, шинэ нисэх буудал ашиглалтанд орсноор харилцаат мужуудаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг Компани аж ахуйн нэгжүүдээ харилцаа холбоотой болгох, хамтран ажиллах боломжийг дэмжих, ОХУ-ын Приморын хязгаартай эдийн засаг, худалдаа, тээвэр логистикийн салбарт тодорхой ажлуудыг тус тусын Засгийн газар, Ерөнхийлөгчдийн дэмжлэгийг авч зохион байгуулах, ХАА, газар тариалан, аялал жуулчлал, гадаад худалдааны салбарт тодорхой ажлуудыг эхлүүлж, бодит ажил хэрэг болгохын төлөө талууд онцгой анхаарал хандуулах, харилцаат мужуудад худалдааны төлөөлөгчтэй болох, төлөөлөгчийн газруудыг байгуулах, харилцан биесийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдхүүнээр бүс нутгийнхаа иргэдийн хэрэгцээг хангах, усан болон хуурай зам, төмөр зам, агаарын замын тээврийг ашиглалтыг нэмэгдүүлэх, тогтмолжуулах, муж аймгийн бизнес эрхлэгчдийг бүхий л талаар дэмжих, олон улсын үзэсгэлэн яармагт оролцуулах, хөрөнгө оруулалтын чиглэлд хамтарч ажиллах боломжийг нээх зэрэг олон асуудлыг ярилцаж, эрчимтэй хамтарч ажилахаар болов.

Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Энхбат тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Владивосток хотноо 2019 оны 7 дугаар сарын 2-4 -ний өдрүүдэд зохион байгуулагдсан ЗХА-ийн орнуудын харилцаат бүс нутгуудын ИТХ-ын дарга нарын 10 дахь удаагийн форумд ЗГХЭГ-с зөвшөөрөл авч, оролцов.

2019 оны 7-р сарын 28-30-ны өдрүүдэд шууд харилцаат Япон улсын Тоттори мужийн Найрамдлын нийгэмлэгийн 33 гишүүн Төв аймагт зочилж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Хүүхэд гэр бүл залуучуудын газрын дэргэдэх Япон хэлний дугуйлангийн сурагчид, Төв аймгийн иргэд найз нөхөдтэйгөө хамтарч 2 муж аймгийн иргэд хоорондын “Найрамдлын жигүүр” арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээний хүрээнд япон хэл сурч байгаа хүүхдүүд япон хэл дээр танилцуулга хийж, япон дуу шүлэг сурснаа зочдод үзүүлж сонирхууллаа. Найрамдлын нийгэмлэгийн гишүүд найз нарынхаа гэрт зочилж хоум стей хийж, хамтдаа бэсрэг наадам зохион байгуулсан.

7-р сарын 7-10-ны өдрүүдэд Тоттори мужийн ахлах сургуулийн сурагчид багш нар, гадаад харилцааны газрын ажилтнуудын хамт хүүхэд солилцооны хөтөлбөрөөр Төв аймагт зочлов. Хүмүүн ахлах сургууль дээр монгол хүүхдүүд багш нарын хамт монгол хоолыг өөрийн гараар хамтран бэлтгэж, үе тэнгийн найз нарынхаа гэрт хоум стей хийв.

Японы Изүмисаногийн хотын хүүхэд багачууд багш нарын хамт 7-р сарын 2-30-нд Төв аймгийн 4-р сургуульд сурагч солилцооны хөтөлбөрөөр зочлов. Хүүхэд багачууд багш нарын хамт сургууль дээр хамтарсан арга хэмжээ зохион байгуулж найз нөхдийндөө зочилж, монгол ахуйтай танилцлаа.

7-р сарын 7-10-ны өдрүүдэд БНСУ-ын Кангвон мужийн Данож фестивалийн зохион байгуулах хорооны төлөөлөгчид Төв аймагт зочилж аймгийн наадмыг үзэж сонирхон, Монгол туургатан театрын уран бүтээлчидтэй туршлага солилцон хамтарсан тоглолтыг 9-ний орой Зуунмод цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулав.

2019 оны 7 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд аймгийн шууд харилцаат БНСУ-ын Кангвон мужийн Гангнюн хотод болсон Олон улсын хүүхдийн урлагийн 18 дахь удаагийн Гангнюны их наадамд Мөнгөнморьт сумын “Бөртэ” хамтлаг багш нарын хамт амжилттай оролцов. /Нийт 2 хүн/

Бүгд Найрамдах Польш улсын Гадаад харилцааны Дэд сайд 2019 оны 7 дугаар сарын 12-нд Төв аймагт айлчилж, аймгийн Засаг дарга бусад удирдлагуудтай уулзав. Аймгийн Баян сум Польшийн Глиноецк хотын хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр хамтарч ажиллахаар боллоо.

2004 оноос хойш 15 жил амжилттай хэрэгжүүлсэн “Кангвон мужийн нэрэмжит хүлэмжийн тосгон” төслийн үйл ажиллагааны хаалтын ёслолын арга хэмжээ Зуунмод хотод Хүлэмжийн 1-р хотхон, аймгийн ЗДТГ-т болов. Төслийн үр дүнг 2 талаас нэгтгэн дүгнэж цаашид илүү өргөн хүрээтэй төсөл хэрэгжүүлж ажиллах боломжтойгоо илэрхийлэв. Арга хэмжээнд Кангвон мужийн ХАА, газар тариалан, техник технологийн хүрээлэнгий захирал, Төв аймгийн Засаг дарга нар, БНСУ-ын элчин сайдын яам, олон улсын КОПИА байгууллага, ХХААХҮЯ, ХААИС-аас төлөөлөгчид оролцсон.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Коммунист намын Төв хорооны Гадаад харилцааны газар хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2019 оны 6 дугаар сарын 24-өөс 7 дугаар сарын 3-ны хооронд БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга нарын сургалтад аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр оролцов.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 07 дугаар сарын 25-ны байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 22 байгууллага 300 гаруй төрлийн үйлчилгээг 6000 гаруй иргэнд, өдөрт дунджаар 350 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад 27, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд 46 мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 4-н дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давхардсан тоогоор 150 гаруй удаа мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэлээ.

7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 8 гомдол санал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Төв аймагт зохион байгуулагдах “Торгоны зам 2019” олон улсын авто уралдааны үеэр 07 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд хоол үйлдвэрлэлийн явцад хяналт шалгалт хийж ажилласан.

ХХААХҮЯ, МХЕГ, МЭЕГ-ын мал төхөөрөх, дулааны аргаар мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд импортлогч орны хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага хангаж буй эсэхэд хамтарсан хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамжаар Төв аймгийн Эрдэнэ сумын “Эрдэнэ хүнс” мах боловсруулах үйлдвэрт хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөхөд 97%-тай бага эрсдэлтэй шалгагдсан.

Төлөвлөгөөт хяналт шалгалт: Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалтыг 4 объектод, 1 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж илэрсэн

зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр уул уурхай, сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 5 объектыг төлөвлөгөөт шалгалт, 3 объектыг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулсан. Шалгалт, зөвлөн туслах үйлчилгээгээр илэрсэн зөрчлийг арилгуулахаар хамтарсан 5 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

Геологи, уул уурхайн хяналтаар: Төв аймгийн Сэргэлэн, Баян сумдын нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 6 объектод төлөвлөгөөт шалгалт, 3 объектыг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулсан. Шалгалт, зөвлөн туслах үйлчилгээгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 3 албан шаардлага, 2 объектод Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 1000000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, 1 зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Байгаль орчин, газар геодези зураг зүйн хяналтын чиглэлээр Сэргэлэн, Баян сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт, 2 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж ажилласан.

Дэд бүтцийн хяналтаар: Хэмжил зүйн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалтыг 4 объектод хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж ажилласан.

Төлөвлөгөөт бус шалгалт: Барилгын техникийн хяналтаар Батсүмбэр суманд үйл ажиллагаа явуулах “Ахмад настны үндэсний төв”-ийн цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын ашиглалтанд оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллалаа.

Эрдэнэ сумын Талын Сондор ХХК-ийн амралтын газар, Баянчандмань сумын Түшиг цайны газар, Сэргэлэн сумын Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын ЭСТО ХХК-ийн газарт бүртгэгдсэн хоолны хордлогын сэжигтэй тохиолдлын үед төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, ЭСТО ХХК—ийн 42, Түшиг цайны газрын 3 ажилтанг шинжилгээнд хамруулж, нийт 18 хоол, 3 ус, 25 арчдасны дээж авч лабораторид шинжлүүлсэн. Лабораторийн шинжилгээний дүнгээр арчдасны 19 буюу 76 хувьд гэдэсний савханцар, хоолны 2 буюу 11,1хувьд E.Coli илэрсэн. Үйл ажиллагааг зогсоох тухай улсын байцаагчийн 1 акт, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчдын хамтарсан 23 заалттай 2 албан шаардлагаар үүрэг өглөө. Зөрчил гаргасан 3 иргэнд хялбаршуулсан журмаар 900 нэгжийн захиргааны арга хэмжээ авч, материалыг прокурорт хянуулж байна.

Хөдөлмөрийн эрүүл ахуй, Байгаль орчны хяналтын чиглэлээр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Таван толгой түлш ХХК –ийн дундын бүсийн нөөц агуулахын ажилчдын гал тогоонд хяналт шалгалт хийн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар 3000 нэгжээр шийтгэл оногдуулж зөрчлийн арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 8 заалттай албан шаардлага хүргүүлэв.

Бусад хяналт: Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хүнс, худалдааны 42, нийтийн хоол үйлдвэрлэлийн 19, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2, нийт 63 аж ахуй нэгж байгууллага, 175 иргэнийг хамруулж ажиллалаа.

Баяр наадмын үеэр төв цэнгэлдэх хүрээлэн, морь барианы талбайгаас 5 цэгээс хөрсний дээж аван мэргэжлийн хяналтын газрын харьяа сорилтын лабораторид шинжилүүлэхэд 15/169/63 дугаартай дээж нь эерэг үзүүлэлт илрээгүй, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 35 аж ахуй нэгж байгууллага, иргэнээс 43 хоолноос дээж авч шинжилгээнд хамрууллаа.

Ургамал хорио цээрийн хяналтын чиглэлээр хяналт шинжилгээ хийх удирдамжийн дагуу хүлэмжийн үйл ажиллагаа явуулж байгаа 3 иргэний 2 төрлийн хүнсний ногооны дээжийг авч сорилтын лабораторит пестицид, нитратын агууламж тодорхойлуулахаар шинжилгээнд хамруулсан.

Аргалант суманд 2019 оны 07 сарын 30-ны өдөр зохион байгуулсан Төв түмний цэнгэл наадам-2019 баярын үеэр хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, химийн шинжээч нар 36 аж ахуй нэгж, иргэнийг хамруулан хяналт тавин ажиллалаа

Геологи, уул уурхайн хяналтаар: Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 2 бичил уурхайн нөхөрлөл, 1 аж ахуйн нэгжийн илэрсэн зөрчилд улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг зогсоож, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн 2 нөхөрлөлд тус бүр 1500000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан. Алтанбулаг суманд 2 аж ахуйн нэгж хуульд заасан нийтлэг үүргээ биелүүлээгүй тул үйл ажиллагааг нь улсын байцаагчийн актаар зогсоож, зөрчлийн хэрэг нээн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Прокурорын газраас Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцуулахаар харьяаллын дагуу шилжиж ирсэн 1 иргэнд 1 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч прокурорын хяналтанд хүргүүлсэн.

Итгэмжлэгдсэн лаборатори: Төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН иргэний хүсэлтийн хүрээнд 179 сорьцыг шалгаж хүлээн авч 182 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон.

Онцгой байдлын газрын хүрээнд: Онцгой байдлын газрын Ёс зүйн алба 7 сард 2 удаа хуралдаж сахилга ёс зүйн зөрчил гаргасан 6 алба хаагчийн асуудлыг хэлэлцэж, газрын ёс зүйн албаны санал дүгнэлтийг газрын даргад уламжиллаа.

Ажлын байран дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал сэдэвт сургалтад Зуунмод сум дахь эрэн хайх аврах салбарын бүлгийн дарга, ахлах дэслэгч З.Отгонзул, Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлсэн “Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа гал унтраах тусгай зориулалтын автомашины жолооч нарын сургалт, дадлагад Зуунмод сум дахь Гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн Гал унтраах автомашины жолооч ахлах ахлагч Д.Оюунбаатар, дэд ахлагч О.Баасандорж, нар хамрагдаж гал унтраах тусгай зориулалтын автомашинаа хүлээн авлаа.

Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан Галын техникийн олон төрөлт спортын бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан клубуудын аварга шалгаруулах тэмцээнд онцгой байдлын газрын баг тамирчид амжилттай оролцлоо.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох мэргэшлийн зэргийн шалгалтад бэлтгэж өдөр бүр Монгол улсын хууль, дүрмээр танхимын сургалт, дасгал нормативын бэлтгэл сургуулилт хийсэн бөгөөд 06 дугаар сарын 28-ны өдөр дэд хурандаа Д.Өлзийбаяраар ахлуулсан мэргэшлийн зэргийн шалгалтын комисс шалгалт авч Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагч нар шалгалтыг амжилттай өгсөн.

Их Монгол улс байгуулагдсаны 813 жил, Ардын хувьсгалын 98 жил, Төв аймаг байгуулагдсаны 96 жил, Зуунмод хот байгуулагдсаны 77 жил, Сэргэлэн сумын уугуул, Монгол улсын төрийн хошой шагналт, ардын жүжигчин Билэгийн Дамдинсүрэн, Монгол улсын төрийн хошой шагналт, ардын жүжигчин Лувсанжамбын Мөрдоржийн мэндэлсний 100 жилийн ойн тэмдэглэн өнгөрүүлэх аймгийн баяр наадамд 2019 оны 07 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд иргэдэд хоолоор үйлчлэх 49 цэгт Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хамтарсан 2019 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 08/09 дугаар мэдэгдэл хүргүүлэн хамтарсан хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгч ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар баталсан Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах журмын 2 дугаар хавсралтаар томилогдсон бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг нь БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Улаанбаатар-Хөшигтийн хөндийн Олон улсын шинэ нисэх буудал чиглэлийн 32,226 км хатуу хучилттай хурдны замын барилгыг ажлыг ашиглалтад оруулахаар 2019 оны 07 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд ажлын хэсэгт Гамшгаас

хамгаалах улсын хяналтын байцаагч ажилласан. Уг хурдны авто замыг 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл **“Үүрэг даалгаврын биелэлт”**-ээр байнгын ашиглалтад авахаар шийдвэрлэв. .

Мөн Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Төв аймгийн Зуунмод сумын 2,6 дугаар багт баригдсан 0,4 км хатуу хучилттай авто зам, 16,2 урт метр төмөрбетон гүүрийн барилгын ажлыг ашиглалтад оруулахаар 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр ажлын хэсэгт орж комиссын гишүүн 96,8 хувийн саналаар **“Байнгын ашиглалт”**-д авахаар шийдвэрлэсэн.

Аадар бороо, хүчтэй салхины улмаас 2019 оны 07 дугаар сарын 15-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн дээврийн адрын хөндийд байрлах нөөцийн усны өрөөний дээврийн хийцийн хучлага хууларч эрүүл мэндийн үйлчилгээ явуулах боломжгүй болсон тухай Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2019 оны 05/191 хүсэлт уламжлах тухай албан бичиг, аймгийн Засаг даргын орлогчийн 07 дугаар сарын 18-ны өдрийн өгсөн үүргийн дагуу Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн хийцийн эвдрэл, галын аюулгүй байдалд Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад Л.Нямдаваа, сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Ц.Бадамханд, Сумын Засаг даргын орлогч Ц.Булган нарыг байлцуулан ажиллаж 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдөр Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 03/02 дүгнэлт үйлдэж холбогдох газарт хүргүүллээ.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2019 оны 07 дугаар сарын 06-ны өдөр **“Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх”** талаар 03/02 дугаар **“Албан мэдэгдэл”**-ийг 8 заалттай боловсруулан аймгийн 27 сумын Засаг дарга нарт хүргүүлэн 2019 оны 07 дугаар сарын 20-ны өдөр биелэлтийг татан авч ажиллаа.

Төв аймгийн Баянцогт сумын Даргиат 3 дугаар багийн нутаг Үлийн хөтөл гэх газар 2019 оны 07 дугаар сарын 18-ны шөнийн 23:47 цагт 2 км-ийн гүнд 4,6 магнитудын газар хөдлөлт болж уг чичирхийлэл нь Аргалант, Баянцогт, Баянхангай, Лүн, Жаргалант сумдад мэдрэгдэж барилга байгууламжийн хийц бүтээцэд ямар нэгэн өөрчлөлт гараагүй талаар сумдын удирдлагатай холбогдож мэдээлэл авсан болно. Энэ талаарх мэдээлэл, газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээний талаар **“ТӨВ”** телевизээр дамжуулан орон нутгийн иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн.

Газар хөдлөлт: 2019 оны 07 дугаар сарын 18 ны оройн 23 цаг 49 минутад төв аймгийн Аргалант, Баянхангай, Баянцогт сумдын нутгаар 4,6 балл хэмжээтэй газар хөдлөлт болсон. Уг гамшигт бэртэж гэмтсэн хүн байхгүй, эвдэрж сүйдсэн байшин барилаг гэр өртөөгүй болно.

Объектын гал: 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Баянчандмань сумын Эрдэнэ 3 дугаар багийн нутаг Наран булаг амралтын газрын хажууд иргэн Д.Цэрэнбадамын эзэмшлийн 10х10 хэмжээтэй байшингийн үүднй хэсэг шатаж байсныг нутгийн иргэд болон Нийслэлийн ОБГ-н ГТУА26-р ангийн 6 албан хаагч 1 техниктэй уг гал түймрийг бүрэн унтраасан.

2019 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Лүн сум Өгөөмөр 2 дугаар багийн нутаг Цагаан хөтөл гэх газар 52-30 УНӨ улсын дугаартай 45 хүний суудалтай автобус бүрэн шатсан.

2019 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Зуунмод сумын Номт 1 дүгээр баг Одонт хөтөл гэх газар 68-02 УНЯ улсын дугаартай DELIKA маркийн автомашин шатсаныг ГТУА24-р ангийн 6 албан хаагч 1 техниктэй бүрэн унтраасан.

2019 оны 07 дугаар сарын 11-ний өдөр Мөнгөнморьт сумын Булаг 3 дугаар багт хуучин хаан банкны 24х12 хэмжээтэй Блокон байшин шатсаныг ГТУА75-р ангийн 9 албан хаагч 1 техниктэй бүрэн унтраасан.

2019 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Алтанбулаг сумын Сумт 1 дүгээр багийн нутагт дэнжийн 6-7 тоотод иргэн Б.Үржинбадамын эзэмшлийн 5 ханатай гэр, эд зүйлийн хамт бүрэн шатаж хувийн өмчийн 8,406,000 төгрөгийн хохирол учирсан байна.

2019 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Заамар сумын Хайлааст 3 дугаар багийн төв Сургуулийн 4x4 хэмжээтэй сендвичин материалтай уурын зуух шатсаныг Цагдаагийн байгууллага шалгаж байна.

Усны холбогдолтой осол: 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Алтанбулаг сум Сумт 1-р багийн нутаг, сумын төвөөс зүүн зүгт 800-900 м зайтай Туул голд морио усалж явсан иргэн Ш.Өлзийхишиг /52 настай эрэгтэй/ живж амь насаа алдсан. 07-р сарын 04-нд цогцсыг нь олж ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгсөн.

2019 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Эрдэнэ сумын Өгөөмөр 1-р багийн нутаг “Өндөр улааны ар” гэх газар иргэн н.Үйтүмэн /21 настай эрэгтэй/ усанд осолдсон Баянголын гол гэх газар живж нас барсан байдалтай олдсон.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, 64.74 хувьтай дүгнүүлэв.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс зарим сумдын нутаг дэвсгэрт ургадаг корбанит, хогийн олсны ургамал устгах “Устгал” нэгдсэн арга хэмжээг хууль хяналт, тусгай чиг үүргийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд орон нутгийн төсөв, аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсвөөс нийт 3.8 сая төгрөгийг зарцуулсан.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 7 сарын дугааруудыг бэлтгэн нийтэд хүргэв.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 52 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 91 иргэд болон сумд, байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 36 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангаж ажилласан.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд бүтээсэн 15 төрлийн богино шторк, 6 төрлийн богино хэмжээний кино, иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг түгээдэг цахим хуудас [“e-khutuch.mn”](http://e-khutuch.mn) болон Хууль зүйн Луужин 1 пейж хуудасны танилцуулга шторк зэргийг орон нутгийн телевиз, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын мэдэл дэх ЛЭД дэлгэц, цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээх болон хууль зүйн чиглэлийн сургалт, сурталчилгааны ажилд ашиглуулах зорилгоор сум байгууллагуудад хүргүүлсэн. “Төв аймаг Хууль эрх зүйн хэлтэс” нэртэй фэйсбүүк хуудсанд нийтэд ач холбогдолтой 13 мэдээллийг оруулж нийтэд түгээсэн.

Сумдын эрх бүхий албан тушаалтнуудаас батлан гаргасан захиргааны 9 шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж хуульд нийцүүлэн зөвлөмж өгөв.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 3 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, шүүх хуралдаанд оролцсон.

Архивын үйлчилгээ: Тайлант хугацаанд архивын эх баримтаас 94 иргэний хүсэлтээр 269 хуулбар хувь, 65 лавлагаа гарган үйлчилсэн бөгөөд 647.500 төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэв. 2 хөмрөгийн 109 хадгаламжийн нэгжийн 5478 хуудас баримтын 23126 хүний нэр, 4641 заалт, тушаалын тоон мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж PDF.JPEG хэлбэрт хувиргав.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр “Төгс перфект энерги” ХХК СХ№76, Эрдэнэ сумын амралтын газрын цахилгаан хангамж 2 хн, “Бадамлам хүч”, “Женурал электропроект” ХХК СХ№76 Алтанбулаг сум ХАА-н зориулалттай барилгын гадан цахилгаан хангамж 2 хн, Иргэн Д.Отгонбаяр СХ№76 Эрдэнэ сум 1 дүгээр баг

Баяндавааны ар талд байрлах мод үржүүлэх газрын гадна цахилгаан хангамж 2 хадгаламжийн нэгжийг хүлээж авлаа.

Архивын Ерөнхий газрын Мэргэжил арга зүйн хэлтэстэй хамтран аймгийн төвийн 25 байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад “Данс, бүртгэл, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт үйлдэх, техник боловсруулалт хийх арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Улсын бүртгэлийн үйлчилгээ:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр: Цахим санд нийт 50,807 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9535, Газар өмчлөх эрхийн 41,272 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 20,633.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 121498470 төгрөгийг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлогоос 82263041, тэмдэгтийн хураамжаас 2756074 төгрөгийг тус тус улсын төсөвт оруулав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт 149 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 117 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 38, хууль хяналтын байгууллагад 34 лавлагаа мэдээлэл тус тус өгсөн. Тэмдэгтийн хураамжийн орлого 8,472,000 төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр: Иргэний гэр бүлийн байдлын 1845 бүртгэл, иргэний үнэмлэх захиалгын 2744 бүртгэл, шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлд 1104 иргэн бүртгүүлсэн байна. Үндэсний энгийн гадаад паспортыг 73 иргэнд олгосон байна. Иргэний баримтын архивын лавлагаа 3138 олгож үйлчилсэн бол хууль хяналтын байгууллагад тэдний хүсэлтийн дагуу 639 лавлагаа гаргасан.

Хяналт шалгалтын чиглэлээр: Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, улсын бүртгэлийн архивын нийт 11533 бүртгэлд хяналт шалгалт хийж 155 бүртгэлийн зөрчил илрүүлж хуулийн хугацаанд зөрчлийг арилгасан. Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрсөн 694 иргэн, хуулийн этгээдэд торгох шийтгэл оногдуулж 18,575,000 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэв. Иргэдээс ирүүлсэн 94 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэв.

Цагдаагийн газрын ажил ажиллагааны хүрээнд: 2019 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар 412 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62 нэгжээр буюу 15.0 хувиар зөрчил 28588 бүртгэгдэж 10631 нэгжээр буюу 37.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 44.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.4 хувиар өссөн.

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 29.8 хувь, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 16.8 хувь, үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 62.4 хувь, Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 44.4 хувиар тус тус өсч, гэр бүлийн хүчирхийлэл 29.4%, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг 22.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор Цагдаагийн төв байгууллагаас улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Орон нутгийн зам- хөдөлгөөн соёл 2019”, “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, Орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын онцлогт тохируулан “Шийдвэрлэлт-2019”, “Цахим”, “Мотоцикл” өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд стандартын шаардлага хангасан хяналтын камерыг байршуулах зорилгоор “Камерын хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Эмээлт”, “Шийдвэрлэлт-2019”, “Тандалт” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архиан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон, шүүхээр баривчлагдсан, албадан саатуулагдсан нийт 74 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авснаас эрүүлжүүлэгдсэн 41, албадан саатуулсан 8, шүүхээр баривчлагдсан 25 иргэнийг код журмийн дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авч ажилласан.

Саатуулах байрны эмч нар саатуулах байранд баривчлах байрны үйл ажиллагааны явцад 18 иргэнд эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, ар гэр, асран хамгаалагчид нь 12 иргэнийг хүлээлгэн өгч ажилласан.

Эрүүлжүүлэгдсэн 41 иргэдээс төлбөр болох 166000 төгрөг, хугацаа дууссан 31 хүмүүжигчээс, төлбөрийн чадвартай 25 иргэний төлбөр 12160000 төлбөрийн чадваргүй 6 иргэнийг багийн Засаг даргын тодорхойлолтоор хааж нийт 1382000 төрийн сангийн дансанд төгрөгийг төрийн сангийн дансанд тушааж ажилласан. Төлбөр төлөлт 97%-тай байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Олон нийтийн хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад 29 удаа 396 алба хаагч 325 тээврийн хэрэгсэлтэй 24 тусгай хэрэгсэл, 614 тусгай хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй 12188 хүн/цагийн үүрэг үүрэг гүйцэтгэж 19650 иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 40 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 14 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5768 жолоочийг 150,300,000 төгрөгөөр торгож ажилласан байна.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд Криминалистикийн шинжилгээ-111, магадлан шинжилгээ-111, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-322, гарын мөрийн санг баяжуулсан-84, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 506 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
07-р сар	398	256	18	636	270	366	42.5%
	3920610.2	2301951.2	531308.2	5691253.2	1159291.7	4531961.5	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр:

Газар тариалан: 2019 оны 07 дугаар сарын 26-ны байдлаар үр тариа 69508 га буюу 76.38 хувь, үүнээс улаан буудай 63788 га буюу 76.85 хувь, тосны ургамал 18912 га буюу 187.25 хувь, төмс 7813 га буюу 130.43 хувь, хүнсний ногоо 1183.34 га буюу 84.52 хувь, тэжээлийн ургамал 9779 га буюу 115 хувьтай байна.

Тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авахад аймгийн хэмжээнд нийт тариалсан үр тарианы 1.4 хувь нь онц, 43.8 хувь нь сайн, 45.3 хувь нь дунд, 9.5 хувь муу гэсэн үнэлгээтэйгээр дүгнэгдэн нэгтгэлийг ХХААХҮЯ-нд хүргүүллээ. Таримал ургамлын

ургалтын үеийн арчилгаа, уринш хийх технологи, ургамал хамгааллын бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын танилцуулга, зөвлөмжийг сумдад хүргүүллээ. Хадлан, ургац хураалтын техник засвар явц 71,7 %-тай байна.

Атрын 60 жилийн ойн тэмдэглэх ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулан, тусгай чиг үүрэг бүхий 5 дэд ажлын хэсгийг Засаг даргын 2019 оны А/435 дугаар захирамжаар байгуулсан.

Шууд харилцаат БНСУ-ын Канвон муж, Төв аймгийн ЗДТГ-тай байгуулсан гэрээний дагуу шинээр байгуулсан “Экологийн боловсрол олгох төв”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Мал аж ахуй: Цаг үеийн ажлын талаар 27 сумдтай цахим хурал зохион байгуулж, хурлаар мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, хадлан тэжээл бэлтгэх, гар тэжээлийн аян өрнүүлэх, өвөлжөөний бууц бэлтгэх, инженерийн хийцтэй худаг гаргуулах ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг, чиглэл өглөө.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 26 суманд 36 инженерийн хийцтэй худаг гаргахаас 7-р сарын 31-ний байдлаар 18 суманд 25 худаг гарч, 69.0%-ийн гүйцэтгэлтэй байна.

Засаг даргын 2019 оны А/355 тоот захирамжаар малчин, мал бүхий иргэдийн бэлтгэх өвс, гар тэжээлийн төлөвлөгөө, сумын аюулгүйн нөөцийн даалгаврыг сумдад хүргүүллээ.

Үйлдвэрлэл, үйлчилгээ: Үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг тэлэх, иргэдийг хямд найдвартай бүтээгдэхүүнээр хангах зорилгоор “Наадам-2019”, “Төр түмний цэнгэл наадам” үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулан давхардсан тоогоор 27 сумын 10 аж ахуй нэгж, 75 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 81,0 сая төгрөгийн борлуулалтаар дэмжигдлээ.

Аймгийн баяр наадмын худалдаа үйлчилгээний салбар хороог хариуцан, худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ зөвшөөрлийг 133 худалдаа, үйлчилгээ цэгт олгож, 4005.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүллээ.

“Хүнсний аюулгүй байдал, үйлчилгээний чанар, галын аюулгүй байдал, хоггүй цэвэрхэн наадам” талаар 70 гаруй худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, иргэдэд ОБГ, МХГ, СХЗХ-ээс сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд аймгийн ЖДҮХС-д 2.4 тэрбум төгрөгийн зээл хүссэн 15 сумын 38 иргэн, аж ахуй нэгжийн төслийг хүлээн авч Дэд хорооны хурлаар хэлэлцүүлжээ. Төслийн иж бүрдэл хангах I шатны шалгаруулалтад 15 төслийн 1081.8 сая төгрөгийн материал буцаагдаж, Дэд хорооны II шатны хурлаар 23-н иргэн, аж ахуй нэгжийн 1411.6 сая төгрөгийн төслийг хэлэлцүүлэн, 4 аж ахуйн нэгж, 13 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 1.0 тэрбум төгрөгийн төсөл дэмжигдэн аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан ХХААХҮЯамны ЖДҮХСанд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Сум хөгжүүлэх сангаас 13 сум 78 иргэнд 612,5 сая төгрөгийн зээл олгож, хугацаа хэтэрсэн 215.7 сая төгрөгийн зээлийн авлагыг бууруулж, 418.1 сая төгрөгийн зээлийг төлүүлэх Шүүхийн шийдвэр гаргуулан эхний хагас жилийн нэгдсэн тайланг ХХААХҮЯ-нд хүргүүлэв.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхэлж буй 94 аж ахуйн нэгжтэй гэрээний дагуу хамтран ажиллаж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээний хөлсний урьдчилгаанд 38.5 сая төгрөгийг олгосон.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тарилгын нийлүүлэлт:

№	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэр	Төлөвлөгөө /хэмжих нэгж/	Нийлүүлэлт /хэмжих нэгж/	Хувь
1	Боомын вакцин	245.0 л	245.0 л	100%
2	Галзуугаас сэргийлэх амьд вакцин	155.0 м.т	90.0 м.т	58%
3	Дотрын халдварт хордлого,	2760.0 л	2760.0 л	100%

	энтербактериозоос сэргийлэх хам вакцин			
4	Дуут хавдараас сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин	700.0 л	700.0 л	100%
5	Гахайн ёломоос сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин	50.0 л	50.0 л	100%
6	Гахайг мялзангаас сэргийлэх амьд вакцин	10.0 м.т	10.0 м.т	100%
7	Сахуугаас сэргийлэх бактерин	200.0 л	200.0 л	100%
8	Сохор доголоос сэргийлэх амьд вакцин	50.0 л	50.0 л	100%
9	Адуу, тэмээг томуугаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин	50.0 л	50.0 л	100%
10	Цусан халдвартаас сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин	2195.0 л	2195.0 л	100%
11	Шөвөг яраас сэргийлэх амьд вакцин	200.0 л	200.0 л	100%

Дээрх 11 нэр төрлийн вакцинжуулалт 71.23% ийн гүйцэтгэлтэй байна. .

Гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 10 сумын 3128 өрхийн 1190.6 мян.тол мал хамруулахаас 1164.7 мян.тол мал хамруулж гүйцэтгэл 97.8% байна. “Мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян” өрнүүлэн нийт 248643 м² талбай ариутгалаа.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний угаалгад 852.4 мян.тол мал, боловсруулалтад 768.3 мян.толгой мал тус тус хамруулаад байна.

2019 оны 07 дугаар сарын 01 өдрөөс эхлэн “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”-ын хэрэгжүүлэн 89 баталгааны тэмдэг, мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг 8775 ширхэгийг Мал эмнэлгийн нэгжүүдэд хүлээлгэн өглөө.

Аймгийн Морин спорт, уяачдын холбоо, Монгол Ви.И.Ти.Нет төрийн бус байгууллага, Америкийн нэгдсэн улсын Мал эмнэлгийн сургагч багш нартай хамтран “Адууны сэргээн засалт, эмчилгээ үйлчилгээ” сэдэвт сургалтын зохион байгуулж 7 сумын 14 уяач, болон 10 залуу малын эмч нар хамрууллаа.

Хөрөнгө оруулалт, Худалдан авах ажиллагааны үйлчилгээ:

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу боловсруулж, тайланг хугацаанд (аймгийн Засаг даргын 2019.07.07-ны өдрийн 01/1357 дугаар албан бичиг) нь Сангийн яаманд хүргүүлж ажилласан.

Аймгийн ТЕЗ-н 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 11 дүгээр хурлын 02 дугаар тогтоол “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай”-оор, Мөн аймгийн ИТХ-н 2019 оны 13 дугаар хурлын 02 дугаар тогтоолд тус тус баталсны дагуу аймгийн ТЕЗ-н 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 87 төсөл арга хэмжээнд 43 244.2 сая төгрөгийг баталж 63 төсөл арга хэмжээнд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 40 755.0 сая төгрөгийн 61 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж хэрэгжилт оны эхний 6 сарын байдлаар 97 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар нийт **46,8** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн. Үүнээс аймагт эрх шилжиж ирсэн, аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байгаа **25,9** тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий **98** төсөл, арга хэмжээ байна.

4 төсөл, арга хэмжээний тендерийг ТӨБЗГазраас тендер зарлах ба үүнээс 1 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан, 2 төсөл, арга хэмжээний тендер зарлагдаж үнэлгээний шатанд байна. 1 төсөл, арга хэмжээ зураг төсөл магадлалын шатанд байна.

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 32434,1 сая төгрөгөөр санхүүжих 36 төсөл, арга хэмжээ байгаагаас эрх шилжин ирсэн 24466,1 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн хөгжлийн сангаар 2452,5 сая төгрөгөөр 24 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээр 3500,0 сая төгрөгөөр 18 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 466,5 сая төгрөгийн 11 арга хэмжээ
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 718,7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн.

Гэрээний хэрэгжилтийн явцыг дэлгэрэнгүйгээр танилцуулбал:

- Улсын хөрөнгө оруулалт /УХО/-ын он дамжин шилжиж буй ажлын явц- 94,5%
- 2019 онд шинээр эхлэх Улсын хөрөнгө оруулалт /УХО/-ын ажлын явц-20.5%
- Аймгийн Орон Нутгийн Хөгжлийн сан /ОНХС/-ын ажлын явц-90.0%
- Аймгийн хөрөнгө оруулалт /ОНЗС/-ын ажлын явц-60.0%
- Аймгийн хөрөнгө оруулалт /БХС/-ын ажлын явц-85.0%
- Аймгийн хөрөнгө оруулалт /Шилжих үлдэгдэл/-ын ажлын явц-91.2%
- 2019 онд тендер шалгаруулалт зохион байгуулахгүй шинээр хийж гүйцэтгэх гэрээ шууд байгуулан хэрэгжүүлж буй ажлын явц-90,0%

НИЙТ Гэрээ байгуулж хэрэгжүүлж буй 2019 оны хөрөнгө оруулалтын ажлын явц 78%-тай байна.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: 2019 онд нийт 52 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж баталсан бөгөөд энэ сард дараах 4 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаад байна. Нийт 64 барилгын зураг төсөлд зөвшөөрөл олгосон бөгөөд энэ сард 11 барилгын эх загвар болон ажлын зураг төслийг хянаж зөвшөөрөл олголоо. Засгийн газрын 2018 оны 68, 171 тоот тогтоолын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 26 барилга байгууламжийн зөвшөөрөл олгосон бөгөөд 7-р сард 11 барилга байгууламжийн эхлүүлэх зөвшөөрөл олгов.

Засгийн газрын 2018 оны 317 тоот тогтоолын хүрээнд аймгийн хэмжээнд 7-р сард 4 барилга байгууламж ашиглалтад өгсөнөөр 2019 онд 19 барилга байгууламж ашиглалтад орлоо. Хот байгуулалтын сүлжээний мэдээллийн санд 5-н барилга байгууламжийг бүртгэн акт өгч ажиллаа.

Хот, суурин газрын өнгөтөрх, гэрэлтүүлэгчигмэглэлийгсайжруулах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжийн барилгыг фасадны гэрэлтүүлгийн зураглалыг батлах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд зураглал хийх, боловсруулах, батлах, материалын тооцоо гаргах ажил манайд хийгдэж байна. Аймгийн төвийн 46 байгууллага аж ахуйн нэгжүүдээс 27 байгууллага аж ахуйн нэгж гэрэлтүүлэг бүрэн хийгдэж, 11 аж ахуйн нэгж гадна тохижилтын зураглал хийж батлуулаад байна. Мөн 7 байгууллага аж ахуйн нэгж барилга шинээр барьж байгаа ба энэ ажлын хүрээнд гэрэлтүүлгийн ажил хийгдэнэ. 19 байгууллага аж ахуйн нэгж гэрэлтүүлгийн ажил хийгдээгүй байна. Цаашид бусад байгууллагуудыг гадна тохижилт, засвар, гэрэлтүүлэг, хаягжуулалтыг хийлгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

Газрын харилцааны үйлчилгээ: Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд Зуунмод-Сэргэлэн сумдын хилийн цэсд өөрчлөлт оруулах санал, Сэргэлэн сумын хилийн цэсд өөрчлөлт оруулах “Мандан судалгаа”-г хийж аймгийн ИТХ-ын тогтоолыг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Мөн Монгол наадмын цогцолборын зориулалтаар Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрээс улсын тусгай хэрэгцээнд авсан 12000 га газрын хэмжээнд өөрчлөлт оруулах санал, аймгийн ИТХ-ын тогтоолыг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн

Монгол наадмын цогцолборын улсын тусгай хэрэгцээний газартай давхцалтай шилжүүлэх шаардлагатай 372 иргэний газрыг чөлөөлөхөд шаардагдах зардлын тооцоог Улсын бүртгэлийн хэлтэс, Аргалант сумын газрын даамалтай хамтран гаргаж Нийслэлийн

ИТХ-ын Дарга, Нийслэлийн Засаг дарга, Монгол наадам цогцолбор ОНӨҮГ-т тус тус хүргүүлсэн.

Аймгийн газрын төлбөрийн төлөвлөгөөний сар улирлын хуваарийн дагуу 7-р сарын төлбөрийн төлөвлөгөө 7-р сарын 29-ний байдлаар 137642.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

2020 оны Газрын төлбөрийн төлөвлөгөөний төслийг маягтын дагуу сумдаас хүлээн авч төслийг хянан, судалгааг нэгтгэж байна. Урьдчилсан байдлаар 2020 оны газрын төлбөрийн төлөвлөгөө 4,6 тэрбум төгрөгний судалгаа гарган аймгийн ИТХ-д танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн Зуунмод сумын 1-р бүсийн инженерийн шугам сүлжээ бүхий 1997-2019 оны 698 нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн архивын нэгж үүсгэсэн.

Сүмбэр, Жаргалант, Борнуур сумдад цахим архивын нэгж үүсгэх ЛМ програм хангамжийн нөхөн бүрдүүлэлт хийх талаар зөвлөмж өгч ажилласан.

Зуунмод сумын Номт багийн нутаг дэвсгэрт 15 нэгж талбарт шинээр Э дугаар авч газар эзэмших гэрчилгээ шинэчлэх, шинээр гэрчилгээ авч гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

Зам тээврийн чиглэлээр: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 2 чиглэлийн авто зам, 16у/м гүүрийг байнгын ашиглалтад хүлээн авч орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замын сүлжээ 6.6км-ээр нэмэгдэж иргэдийн тав тухтай зорчих нөхцөл бүрдэж байна.

- Зуунмод сумын 2, 6-р багийн 0.4км автозам, 16у/м төмөр бетон гүүрийг ашиглалтад хүлээн авлаа.
- Борнуур сумын Аглаг бүтээлийн хийд чиглэлийн 6,2км авто зам

Мөн 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдахаар төлөвлөсөн Алтанбулаг сумын чиглэлийн 13,7 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр Ялгуусан компани шалгарч гэрээ байгуулан ажил эхлээд байна.

Байгаль орчны чиглэлээр: “Монгол-Солонгосын Ногоон хэрэм төсөл”-с 2011 онд ойжуулсан 2, 3, 5, 6 дугаар талбайд тооллого хийж, хашаа хамгаалалт тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ургалт, өсөлт хангалттай амьдралтын хувийг тогтоох ажлыг зохион байгууллаа.

Алтанбулаг суманд хууль бус үйл ажиллагаа эрхэлж буй Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд МХГазар, Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалт хийж 2 иргэнд зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Алтанбулаг суманд “Хонины найр эвент” арга хэмжээг 5 жилдээ “Баянсонгинот” малчны бүлэг, “Хустай” БЦГ-тай хамтран зохион байгууллаа. Өвөр монгол, Герман улсаас жуулчин 35, дотоод аялагч 30, зохион байгуулагч 20 хүний бүрэлдэхүүнтэй нийт 85 жуулчид, аялагчид оролцлоо. Тус арга хэмжээг Урлагын тоглолт, Уламжлалт аргаар эсгий хийх, Цайны баяр, цагаан идээ, хөхүүртэй айраг гэх мэт монгол аж ахуй ёс заншлыг дэлгэн сурталчиллаа. Малчны бүлгийн 1 айл өрх жилд дунджаар 300-400 жуулчин хүлээн авч байгаа бөгөөд 13 сумын 102 айл өрх нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал үйл ажиллагаа эрхэлж байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: Тайлант хугацаанд “Баталгаажуулалтын зөвлөл”-ийн хурлыг 6 удаа, “Баталгаажуулалтын салбар зөвлөл”-ийн хурлыг 5 удаа, нийт 11 удаа хурал зохион байгууллаа. Зуунмод, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Эрдэнэсант сумдад ажиллан 178 худалдаа, үйлчилгээний газраас Тохирлын гэрчилгээ аваххүсэлт ирүүлснээс зөвлөлийн хурлыг үндэслэн 135 үйлчилгээ, бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олгосон.

“Хэмжил зүйн нэгдсэн лаборатори” нь Зуунмод, Баян, Батсүмбэр, Эрдэнэсант, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Баянжаргалан, Баянчандмань, Архуст, Мөнгөнморьт сумдын худалдаа, үйлчилгээний тооцоо, хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ оношлогоонд ашиглагдаж байгаа заавал баталгаажуулалтад хамрагдах нийт 3738 ш хэмжүүр, хэмжих хэрэгслийг “Хэмжил зүйн тухай” хууль болон холбогдох стандартын дагуу ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Эзэлхүүн зарцуулалтын хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын ажлыг: Сэргэлэн, Аргалант, Зуунмод сумдад үйл ажиллагаа явуулж буй нийт 6 ШТС-ын хэмжих хэрэгслийг баталгаажуулсан. Үүнд: НИК төв нефть хангамж салбар–1 ШТС, Гүн Зэгстэй ХХК-ний -3 ШТС, МТ маркет ХХК-ний–2 ШТС-ын нийт 27 хэмжих хэрэгсэлд ээлжит баталгаажуулалтыг хийж гүйцэтгэв.

Массын хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын ажлыг : Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 32 ш жин, туухайг баталгаажуулсан.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: 2018-2019 онд шилжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлын явцын мэдээллийг долоо хоног бүр БСШУСЯ-нд тайлагнасан. 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гарган БСШУСЯ-д хүргүүлээ.

МУЗГ-ын “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” албан даалгаварын хэрэгжилтийг хүргүүлэв.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн 2020 оны төсвийн төслийг 105 байгууллагаас авахаас 100 байгууллага нь өгсөн байна. Нэгтгэлийг 08 дугаар сарын 02-ны дотор холбогдох яамдад нь хүргүүлнэ.

Театрын үйлчилгээ: Тайлант хугацаанд Их зохиолч Д. Нацагдорж, АЖ Б.Дамдинсүрэн нарын “Учиртай гурван толгой” дуурийг сэргээн тавьсан.

Тулгар төр байгуулагдсаны 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98, Төв аймаг байгуулагдсаны 96, Монгол Улсын Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт Б. Дамдинсүрэн, Л. Мөрдорж нарын мэндэлсний 100 жилийн ойн баяр наадмын хүндэтгэлийн тоглолт, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Хүндэтгэлийн тоглолтод Монгол туургатан театрын уран бүтээлчид оролцож, нийт 650 иргэд, үзэгчдэд үйлчилсэн.

Аймгийн Шууд харилцаат БНСУ-ын Канвон мужийн Дано урлагийн наадмыг зохион байгуулагч нар 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Төв аймагт айлчлан ирж Монгол туургатан театрын уран бүтээлчидтэй хамтран соёл урлагийн байгууллагын албан хаагчдад урлагийн тоглолт зохион байгуулсан.

Музейн үйлчилгээ: Тайлант сард 1479 үзэгчид үйлчилж, 869000 төгрөгийн орлого төвлөрүүлээ.

Иргэд, хүүхэд залууст зориулсан танин мэдэхүй, боловсролын ажлын хүрээнд “Соёлын өв бидний бахархал” сэдэвт илтгэлийн уралдаан, уулзалтыг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Зуунмод ЕБ-ын 4, 5 дугаар сургууль, Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн 35 сурагч, түүх, нийгмийн ухааны багш нар оролцов.

Олон улсын Музейн өдрийг угтаж Монгол улсад банк санхүүгийн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойд зориулсан “Монгол Улсын зоос, мөнгөн тэмдэгт (1925-2017)” сэдэвчилсэн үзэсгэлэнг зохион байгууллаа.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: 2019 оны 7 дугаар сард 246 байнгын уншигч, 722 иргэсэд, нийт 968 уншигчдад 1365 ном олгон уншуулсан.

“Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан аймгийн нийтийн номын сангаас “Монгол наадам” номын үзэсгэлэнг 26 номоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргалаа.

Номын сангийн үйлчилгээг иргэдэд сурталчлах, хүртээмжтэй хүргэх, номыг бүтээлчээр унших арга соёлд суралцах, гэр бүлээр нь ном уншуулах зорилгоор Зуунмод сумын 5 багийг хамруулан “Зуны зугаатай уншлага” арга хэмжээ зохион байгуулж 5 багт үйлчилгээг хүргэн нийт 403 уншигч хамруулан ажиллалаа.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: 2019.07.03-нд Зуунмод сумын аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээн зохион байгуулж 8 багийн 70 гаруй тамирчид оролцсон.

2019.07.05-06-ны өдрүүдэд Баянжаргалан сумын уугуул МУ-ын мэргэн Д.Өлзийбат агсны нэрэмжит их сурын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж 18 аймгийн 28 багийн 503 харваач оролцлоо.

Төв аймаг байгуулагдсаны 96 жилийн ойн их баяр наадмаар сурын харваанд насанд хүрэгчдийн 110, өсвөрийн 26, шагайн харваанд 18 багийн 138 харваач, үндэсний бөхийн барилдаанд 256 бөх зодоглон наадамчин олноо баясгалаа.

Уралдааны дугуйн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 07-р сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдаж манай баг тамирчид 2 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр эзэлсэн.

Аймгийн БТС-ын Газраас 2019 оны 7-р сард улсын аварга шалгаруулах тэмцээн 1, нийт 3 арга хэмжээ зохион байгуулж 823 тамирчин хамруулж улсын аварга шалгаруулах тэмцээнээс 7 медаль хүртлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Сумын Хүүхдийн чуулганаас өргөмжлөгдөн сонгогдсон “Хүүхдийн элч” болон 19 сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, 7 хүүхдийн элч, 3 нийгмийн бодлогын мэргэжилтний сургалт зохион байгуулсан.

Залуучуудын хөгжлийн төв, Биеийн тамир спортын газар, “Эх нутгийн иргэд” ТББ, “Төв аймгийн залуус” ТББ-тай хамтран хөл бөмбөгийн спортыг сонирхон хичээллэдэг хүүхэд, залуучуудыг дэмжих, тоглогчдын ур чадварыг сайжруулах, нөхөрсөг харилцаа бий болгох зорилгоор, “Номт”, “ZMD”, “Баян”, “Шүүх”, “Gangs” зэрэг 5 багийн 70 гаруй тамирчдыг хамруулан “ZUUNMOD CUP-2019” хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг Зуунмод хотноо 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулав.

2019 оны 06 сарын 25-30-ны өдрүүдэд “Монголын үндэсний 6-р Жембори” цугларалт Олон улсын хүүхдийн Найрамдал төвд зохион байгуулагдаж Зуунмод сумын 10 скаут хүүхдийг багшийн хамт оролцуулж 1500000 төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Баяр наадам өдрүүдэд хурдан морины уралдааны уралдаанч хүүхдийг цахим бүртгэлд бүртгэж, асран хамгаалагч уяач нарт 500 ширхэг гарын авлагыг тараан зөвлөгөө өгч, аюулгүй байдлыг хангасан. Хамгаалалтын иж бүрэн хувцастай, цахим бүртгэлд орсон, гэнэтийн ослын даатгалд даатгуулсан хүүхдийг хурдан морины уралдаанд оролцуулсан ба 6 насны 545 морь унах 212 хүүхдийг цахим бүртгэлд оруулсан. Хурдан морины уралдааны үед 22 хүүхэд мориноос унаж, 13 хүүхэд гэмтэлгүй, 9 хүүхэд хөнгөн, хүндэвтэр гэмтэл авч, 6 хүүхэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ авч, 3 хүүхэд ГССҮТөвд хүргэгдэн эмчлүүлсэн байна.

Архуст сум байгуулагдсаны 60 жил, Баянцогт сум байгуулагдсаны 90 жил, “Хатан Туулын хурд-2019” баруун бүсийн уралдаан, “Тахийн хүлэгч-2019” хойд бүсийн уралдаануудад ажиллаж 1764 морь унах 618 уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган, насны хязгаар, гэнэтийн ослын даатгал, эцэг эхийн зөвшөөрөл, хамгаалалтын хувцас хэрэглэлд хяналт тавьж, цахим бүртгэлд бүртгэсэн. Дээрх уралдаануудад 20 хүүхэд мориноос унаснаас 8 хүүхэд эмнэлгийн анхан шатны тусламж авч, 2 хүүхэд дараагийн шатны эмнэлэгт хандсан. Уралдаанч хүүхдүүдийн биеийн байдал хэвийн байна.

“Хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Лүн, Эрдэнэсант, Жаргалант, Сүмбэр сумдын Хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн.

Хүүхдийн тусламжийн 108 утасны төвд бүртгэгдсэн мэдээллийн дагуу Сүмбэр сумын иргэн О-ынд очиж нөхцөл байдлын үнэлгээ хийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нь эмнэлэгт үзүүлж, ээж Н-д Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдээ асарч хамгаалах талаар зөвлөгөө өглөө. Мөн Хүүхдийн тусламжийн 108 утасны төвд бүртгэгдсэн мэдээллийн дагуу Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Мөрөөдөл” зуслангийн үйл ажиллагаанд “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS5633:2019 стандартын дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулж, багш ажилчдад “Хүүхдийн хувийн онцлог, халдашгүй байдал, хүүхэдтэй зөв харилцах” талаар сургалт мэдээлэл хийлээ.

“Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж буй өрхийн 10-12 насны 9, зорилтот өрхийн 6 нийт 15 хүүхдийг Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулдаг “Дүүлэх тогоруу” хүүхдийн зусланд 5 хоног амрааж, хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, арга хэмжээнд хамрууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2019 оны 7-р сарын байдлаар /өссөн дүнгээр/ 1857 иргэнд 2104.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1192 иргэнд 558.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1088 иргэнд 395.5 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1484 ахмад настанд 227.2 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 397 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 73.7 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1599 эхэд 209.3 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Алдарт эхийн одонтой 9017 эхэд 1207.8 сая төгрөг, алдар цолтой 59 ахмад настанд 64.5 сая төгрөг, 4975 ахмад настанд 420.1 сая төгрөгийн насны хишгийг олголоо. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 5403 эхэд 1616.4 сая төгрөгийн тэтгэмж, 3 ба түүнээс дээш тооны 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон 276 эх /эцэг/-т 160.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

ЭМГ, ХХҮГ, АНЭ, ӨЭМТ, Солонгос эмч нар хамтран Зуунмод сумын зорилтот өрхийн 223 хүүхдэд шүдний үзлэг оношилгоо, эмчилгээ, эрүүл ахуйн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. Сайн дурын ажилтнууд хүүхдүүд, эцэг эх, асран халамжлагч нарт шүд угаах арга, амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөө өгч, шүдний оо, сойз, гарын бэлэг тараасан.

Ахмадын зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Залуу хүн хөдөлмөр эрхлэхийн ач тус” гэсэн сэдвээр сургалт зохион байгуулж Зуунмод сумын 1, 2, 3, 6-р багийн зорилтот өрхийн 78 иргэн хамруулсан мөн ахмадын зөвлөх эмчтэй хамтран 0-3 настай хүүхдийн асаргаа сувилгааны талаар сургалт зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан 67 иргэнд ХЭНҮ, нээлттэй зарлагдсан ажлын байрны зарыг утсаар мэдээлэл хүргэж, ажил хайгч 25 иргэнийг ХЗЗБМНС-д бүртгэн баталгаажуулсан. Түр болон байнгын ажлын байранд 11 иргэнийг зуучилсан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад Эрдэнэ сумын 20 иргэнийг хамруулсан. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 32 иргэн ажил хайгчаар бүртгэж, 12 ажил олгогч байгууллага, 26 сул чөлөөтэй ажлын байр, 35-н ажилд зуучлагдсан иргэн, 56 шинэ ажлын байрны мэдээллийн санд оруулсан. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 17-н иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн. Түр ажлын байранд ажилласан 700 гаруй иргэдийн мэдээллийг сумдаас авч мэдээллийн сан үүсгэлээ. Зуунмод суманд бий болсон шинээр бий болсон 10 гаруй ажлын байрыг бүртгэн 20-иод ажлын байрыг баталгаажуулан

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Өндөрширээт, Лүн, Баянхангай, Баянцагаан, Баян зэрэг 9 сумын 28 өрхийг нийт 2697 толгой малаар малжуулж 128000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг ХЭДСангаас зарцууллаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулж 16 багийн 38 иргэнд 54 цагийн сургалтыг зохион байгуулж эхний шатны шалгаруулалтанд 9 багийг шалгаруулснаас 2 баг хасагдаж 7 багийг хурдасгуур хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлээд байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Цахим хяналтыг сайжруулах чиглэлээр 2019 оны хагас жилийн байдлаар мэдээллийн баазад алдаатай бүртгэгдсэн нийт 1839 зөрчил байгаагаас 762 буюу 41.4%-ийн мэдээллийн зөрчлийг арилгасан.

НДХ-ийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс хуралдаж, нийт 189 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 30 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 143 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 14 иргэнийг цуцалж, 2 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг буцаасан байна.

Нийт аймгийн хэмжээнд 408 цэргийн өндөр насны тэтгэвэр авагчид 241,4 сая, 11381 өндөр насны тэтгэвэр авагчид 3938,4 сая, 1742 тахир дутуугийн тэтгэвэр авагчид 510,3 сая, 596 тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид 173,1 сая төгрөгийн тэтгэвэр нийт 14127 тэтгэвэр авагчдад 4.8 тэрбум төгрөгийн тэтгэврийг олголоо.

Аймгийн хэмжээнд 120 хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 18.7 сая, жирэмсэн амаржсаны тэтгэмж 105 даатгуулагч 126,3 сая, оршуулгын тэтгэмж 37 иргэнд 39 сая, ажилгүйдлийн тэтгэмж 34 даатгуулагч 47.8 сая төгрөг нийт 231,8 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Байгууллагын болон сангуудын төсвийн гүйцэтгэлийн тайлан, Төсвийн тухай хуулийн дагуу 2019 оны эхний хагас жилийн тайланг бэлтгэж дээд шатны байгууллагад хүргүүлэн шалгуулж нэгтгэсэн тайланг сангийн Э-тайланд шивж баталгаажуулан ажиллалаа.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Сөүлийн эрүүл мэндийн сайн дурын сантай байгуулсан харилцаа, хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2 дахь жилдээ БНСУ-аас шүдний нарийн мэргэжлийн эмч нар, тоног төхөөрөмжийн инженер, сайн дурын ажилтнууд, орчуулагч нийт 24 хүний бүрэлдэхүүнтэй баг 2019 оны 07 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Зуунмод суманд ажилласан. Энэ хүрээнд Эрүүл мэндийн газар, Сөүлийн эрүүл мэндийн сайн дурын сан, МУЗН хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн оношилгооны төвийг нээж өгсөн. Сөүлийн эрүүл мэндийн сайн дурын сангаас шүдний эмчилгээний сандал-2, эхо, эмнэлгийн бусад хэрэгслүүд нийт 328.863.900 воны буцалтгүй тусламж үзүүлсэн.

Артерийн даралт ихсэлтийг эрт илрүүлэх, цус харвалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Цусны даралтаа тогтмол хянаж хэвшигчээ” аяныг аймгийн Засаг даргын А/403 тоот захирамжаар өрнүүлж байна. 7 сарын байдлаар 3 байгууллага иргэдийн даралт хэмжих аппараттай болсон. Мөн ТBS телевизээр “Зочны цаг” ярилцлагад НЭМХ-ийн дарга оролцож, мэдээлэл хийсэн ба 4 төрлийн шторкийг иргэдэд тогтмол хүргэж байна.

Иргэдийн амралт, аялал зугаалгын улирал эхэлж байгаатай холбогдуулан зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлье, үер усны аяны аюулаас сэрэмжлүүлж байна сэдвээр 13 төрлийн мэдээлэл, Дэлхийн гепатитийн өдрийг угтан 8 төрлийн сэрэмжлүүлэг мэдээллийг ДУС, facebook зэрэг олон нийтийн сүлжээгээр сурталчилж нийт 200 гаруй хүнд хүргэсэн.

Батсүмбэрийн Асрамжийн газарт мэргэжлийн сувилагч дутагдалтай учир тухайн орон нутгийн 4 хүүхдийн сургалтын төлбөр болох 7,084,000 төгрөгийн асрамжийн газраас шийдвэрлүүлж, сургалтын гэрээ байгуулан АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн дипломын ангид элсүүлэн сургахаар болов.

Нэгдсэн эмнэлгийн Төрөх тасагт НҮБ-ийн хүн амын сангаас телемедицины өрөөг 8,550,000 төгрөгөөр тохижууллаа. Аймгийн тусгай зөвшөөрөл олгох онцгой комисстой хамтран хувийн хэвшлийн байгууллагуудаас 8 ЭМБайгууллагад хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн.

Сэргэлэн СЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холбоотой өргөдлийн дагуу Сэргэлэн суманд ажилласан.

Сувилагч солилцоонд хамрагдсан 20 сумын ахлах сувилагч, Нэгдсэн эмнэлгийн 20 ахлах сувилагч, нийт 40 сувилагчийн санхүүгийн баримтыг авч, солилцон ажилласан тухай нэгдсэн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Тарваган тахлын тархвар судлалын заалтаар хийгдэх дархлаажуулалтыг 10 хоногийн хугацаанд зохион байгуулахад 500 иргэн хамрагдаж, мэдээг гарган ХӨСҮТ, ЗӨСҮТ-д хүргүүлсэн. Хөшигийн хөндий Онгоцны буудалд хоолны хордлогот халдвараар 3 хүн өвчилсөн. Тохиолдол тус бүрт голомтын арга хэмжээг авч ариутгал халдваргүйтгэл хийж, тайланг ХӨСҮТ-д хүргүүлэв. 7 дугаар сард халдварт өвчний нийт 21 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс Гар хөл амны өвчин 7, Салхин цэцэг 2, Гэдэсний халдварын 11 тохиолдол тус бүр бүртгэгдсэн.

Дэлхийн хепатитын эсрэг өдрийг угтуулан АНЭ, ӨМТ-тэй хамтран Элэгний В, С вирусын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, 40 иргэнийг хамруулсан. Үүнээс В вирустэй 2, С вирустэй 3 иргэн илэрсэн бөгөөд дараагийн шатны эмнэлэгт хандахыг зөвлөн ажилласан.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2019 оны эхний 6 сарын байдлаар 436 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 5 тохиолдлоор буурсан ба 436 нярай бүртгэгдсэн байна. Нийт 76153 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 38461, амбулаторийн үзлэг 34514, идэвхитэй хяналтын үзлэг 3178 хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 3737 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэнээс алсын дуудлага 74 буюу 2.0%, осол гэмтлийн дуудлага 59 буюу 1.6%-ийг эзэлж байна. 3736 өвчтөн 31931 ор хоног ашиглан хэвтүүлэн эмчлүүлсэн ба дундаж ор хоног 8.4 байна.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар: Төсвийн орлого, зарлагын сар улирлын хуваарийг аймгийн Засаг даргын 2019 оны А/32 тоот захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2019 оны эхний 6-р сарын байдлаар аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөө 9315,4 сая төгрөг оруулахаас 9320,9 сая төгрөг оруулж, төсвийн орлогын төлөвлөгөө 5,5 сая төгрөг буюу 100,1 хувиар биелсэн.

Сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 132,8 хувь буюу 564,0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Сумдын төсвийн орлого давж биелэхэд үйл ажиллагааны орлого 126,0 сая төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 122.1 сая төгрөг, ҮХЭХ борлуулсаны албан татвар 24,0 сая төгрөг, Хог хаягдлын хураамжын орлогоор 5,4 сая төгрөг, хүү торгуулийн орлого 83,7 сая төгрөг, бусад орлого 112,1 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн нь нөлөөлжээ.

Баян, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Зуунмод зэрэг 5 сумд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулжээ.

Аймгийн төвлөрсөн төсвийн орлогоос ҮХЭХ-ийн орлого, ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Баян, Баянжаргалан, Заамар, Борнуур, Сэргэлэн, Сүмбэр, Эрдэнэ зэрэг 7 сум тасалсан байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар: Эхний 06 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 50.309.400,8 мянган төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 40.494.836,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулиудад 27.710.307,0 мянган төгрөг
 - Хүүхдийн цэцэрлэгт 12.784.529,0 мянган төгрөг тус тус олгоод байна.
- Эрүүл мэндийн сайдын багцаас 4.992.968,1 мянган төгрөгийг олгосон.Үүнд:
- Сумдын эрүүл мэндийн төвд 4.863.833,7 мянган төгрөг
 - Өрхийн эмнэлэгт 129.134,4 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 278.972,8 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 236.222,1 мянган төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 19.457.138,7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 12.203.445,8 мянган төгрөг

- Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 6.036.754,3 мянган төгрөг
- ОНХСангуудад 1.216.938,6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар: 2019 оны 6-р сарын ХБГүйцэтгэлээр сумд, болон төсөвт байгууллагууд нийт 98.766,6 мянган төгрөгийн авлага, 381.066,3 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 117.601,4 мянган төгрөг буюу 30,8 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 112.989,9 мянган төгрөг буюу 29,6 хувь нь цалингийн өглөг, 32.223,3 мянган төгрөг буюу 8,4 хувь нь НДШимтгэлийн өр, 25.654,1 мянган төгрөг буюу 6,7 хувь нь гэрэл цахилгааны зардлын өгрлөг, 36.299,9 мянган төгрөг буюу 9,5 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 56.297,7 мянган төгрөг буюу 14,7 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн 97 зорилт 287 арга хэмжээг нэгтгэж, аймгийн ИТХТ-ийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн 72.32 хувьтай дүгнүүлэв.

№	Үзүүлэлт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц						Гүйцэтгэлийн хувь	Оноо
				Хэрэгжилт			Үр дүнгүй 0% /0-30/	Үнэлэх боломжгүй			
				Үр дүнтэй 100%	Тодорхой үр дүнд хүрсэн 70%	Эрчимжүүлэх шаардлагатай 40%					
1	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	10	28	10	12	6			74.29	3.71	
2	Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого	27	80	10	43	15		12	67.73	3.39	
3	Дэд бүтэц, төв суурингийн хөгжлийг хангах бодлого	13	63	14	28	13		8	70.54	3.53	
4	Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого	11	32	3	14	10		5	62.22	3.11	
5	Нийгмийн хөгжлийн бодлого	19	48	23	19	5		1	82.13	4.11	
6	Нутгийн удирдлага, хууль хяналтын салбар	17	36	13	16	4		3	79.09	3.95	
	НИЙТ	97	287	73	132	53		29	72.32	3.33	

Аймгийн Засаг даргын захирамжийн 2019 эхний хагас жилийн хэлтэс, агентлаг, харьяа байгууллага сумдын тайланд ХШҮ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулав.

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		311
Бүрэн хэрэгжсэн	100%	141
Хэрэгжих шатанд	70%	135
Хэрэгжилт хангалтгүй	30%	8
Хэрэгжээгүй	0%	17
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	10
Хэрэгжилтийн дундаж		79.04%

Аймгийн ИТХ, ИТХТ-ийн 2019 эхний хагас жилийн хэлтэс, агентлаг, харьяа байгууллага сумдын тайланд ХШҮ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХурлаар хэлэлцүүлэн баталгаажуулав.

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		203
Бүрэн хэрэгжсэн	100%	53
Хэрэгжих шатанд	70%	102
Хэрэгжилт хангалтгүй	30%	11
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	6
Хэрэгжилтийн дундаж		76.93%

ISO-9001:2015 чанарын менежментийн тогтолцоо баталгаажуулалтад хамрагдахаар хүсэлтээ өгөв.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/361 захирамжаар Монгол Улсад зохион байгуулагдах “Торгоны зам” Олон улсын авто ралли тэмцээний бэлтгэл хангасан. Төлөвлөгөөний дагуу гарган ажлын хэсгийн гишүүд болон холбогдох байгууллагуудад хугацаатай үүрэг өгч, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн байгуулагдсан хуарангийн тохижилт үйлчилгээ, орон байр, ус, эрчим хүчний хангалт, хог хаягдал, хоол хүнсний асуудлын бэлтгэл хангасан. Тус тэмцээний үеэр аймгийн 9 сум, 21 багийн нутгийг дамжин 800 гаруй километр замыг туулан 3 уралдаан болсон бөгөөд осол зөрчилгүй гараагүй.

Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын жил, Халх голын дайны ялалтын түүхт 80 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан Төв аймгийн харилцаат БНСУ-ын Бүтэн их сургууль, гадаад дахь сайн дурын үйл ажиллагааны хүрээнд Монгол улсын баатар байлдагч Д.Самдангийн хөшөөг тохижуулан цэцэрлэгжүүлж, 60 ширхэг мод суулгасан.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар